

Манмин Мэдээ

№ 51 2014 оны 10 сарын 5

“Нар ид төөнөж, аагим халуун болох үед сүмээ байгуул”

Зөвхөн дуулгавартай байдлаар орон нутагт ба дэлхий дахинаа сайн мэдээ тараасны үр дүн

Хайрт Бурхан Аав минь,
Өнөөдөр ч гэсэн энэ хүү тань Аавын жинхэнэ хүслийг мэдэхийн тулд ууланд гаран Бурхан Аавын өмнө өвдөг сөгдөн байна.

Миний хайрт Бурхан Аав аа,
Таны Үг надтай хамт байхгүй бол Бурхан Аавын болоод Эзэнийхээ сэтгэл зүрх хүслийг хэрхэн яаж мэдэх билээ?

Таны үг миний хөтөч болж
Намайг Тантай холбож өгсөн уяа билээ
Хэдийгээр Танд итгэдэг нь олон боловч
Бурхан Аавын жинхэнэ хүслийг ойлгосон нь нэг ч байхгүй ба
Таны зүрх сэтгэлийн гүн зүйлийг ч ухаарч чадахгүй байна.

Эхлэлээс аваад Илчлэлт ном хүртэл
Бурхан Аавын эцэс төгсгөлгүй гүн гүнзгий хүслийг тодорхой мэдүүлж өгөөд
Миний залбирал Бурхан Аавд сэтгэлд хүрч Библийн агуу нууцуудыг дэлгэн ухааруулж өгөөч.

Энэ хүү тань Бурхан Аавын энэхүү агуу хайрыг л тараахыг хүсэн тэмүүлж
Үй олон хүмүүс Таны талаар буруу ташаа ойлгохгүйгээр зөвхөн Танд л чин сэтгэлээсээ итгээсэй хэмээн хүсэж байна.

Хайрт Бурхан Аав аа, Эзэн минь
Таны хүсэл тааллыг тань мэдэхээр ууланд гарч өвдөг сөгдөн залбирч буй тул
Зөвхөн Бурхан Аав Таныг л, Эзэн Таныг зүрх сэтгэл минь туйлаас хүсэмжилж байна.
Нулимс минь усны урсгал адил тасралтгүй урсаж,
Бурхан Аавын энгэрт тэврүүлэх мэт, Эзэний өвөрт буй мэт энэ газарт Таны сэтгэл, хүсэл тааллыг тань мэдрэхийг л хүсэж байна.

Бурхан Аав минь
Таныг санан, санан сэтгэл сүнс үргэлжид Таныг хүсэмжилж байна. Тань руу тэмүүлж байгаа миний сэтгэлд эцэс төгсгөл гэж үгүй билээ.

Энэ сүмийг байгуулах тухайн үед И Жей руг пастор Библийн 66 номыг судлан Бурханы хүслийг итгэгч нартаа дамжуулахын тулд мацаг барин уулан дээр залбирч байх үеийн залбирлын хэсгээс...

Шинэ гэрээний Үйлс номон дээр гардаг анхны цуглаан шиг тэмдэг болон гайхамшигт үйлсүүд маш ихээр илрэн гардаг цуглаан, өдөр бүр нэг сэтгэлээр Бурханы өргөөнд цуглахыг хичээдэг цуглаан, Бурханыг магтаж, бүх ард түмний хайр хүндэтгэлийг олж, аврал хүртсэн итгэгчдээр өдөр бүр өсч буй цуглаан (Үйлс 2:43-47), бүр цаашлан Илчлэлт 3:7-13д Филадельфи дахь чуулган адил ерөөл хүртсэн Манмин Төв сүм байгуулагдсаны 32 жилийн ойн баярыг угтан Ариун Гурвал Бурхандаа бүхий л талархал ба алдрыг өргөө.

1982 оны 7-р сарын 25ны өдөр солонгосын талбайн хэмжүүрээр арав гаруйхан пёон буюу 40м2 орчим талбайтай байранд хүүхдүүдийг оролцуулаад 13 хүний гишүүнтэйгээр анх Манмин сүм нээлтийн цуглаанаа эхэлж байсан юм. Түүнээс хойш И Жей руг пастор ба Манмин төв сүм нь дэлхийн өнцөг булан бүрт буй 10000 гаруй салбар сүмүүдтэйгээ хамтдаа Ариун Сүнсний гайхамшигтай хүч чадлыг харуулж, ариун зар сайн мэдээг тунхагласаар ирсэн юм. Энэ хэмжээнд хүрсэн нь зөвхөн Бурханы үгэнд дуулгавартай байсны үр жимс мөн. Иерусалимд бий болсон анхны сүмд хавчлага дарамт ирсэнээр итгэгчид нь тал тал тийшээ бутран явж дэлхийд сайн мэдээ тарсаны адилаар Манмин сүмд ч мөн итгэлийн хувьд хавчлага дарамт ирсэн ч тавхан жилийн дотор 3000 итгэгчтэй болж, үүний үр дүнд солонгосын орон нутагт болон гадаад улс руу сайн мэдээ тараах үүд хаалга нээгдсэн юм.

1991 оны 7 сард Есүс Христийн Нэгдсэн Ариун урсгал чиглэл Солонгост биелэлээ олж, 1992 онд И Жей руг пастор Солонгосын Христэт итгэгчидийн ‘Ариун Сүнсний Их Тэсрэлт 92 Нэгдсэн Их Цуглаан’, ‘Тугаар тогтнолын өдрийн 50 жилийн ойн баярын Их Хурал’-ын ерөнхийлөгчөөр ажилласан. 1993 онд Манмин сүм нь дэлхийн топ 50 сүмийн нэг мөн гэж Америкийн *Christian World* сэтгүүлд гарсан билээ. 1998 онд эхлэсэн 3 удаагийн сорилтоор дамжуулан Манмин Сүм хуулийг хэрхэн яаж хайраар биелүүлэх, сүмийн өсөлтөнд хэрхэн бат бөх суурь тавихыг суралцсан юм. 2000 оноос хойш 2 дахь үед сүмийн алсын хараа үйлчлэл дэлхий дахинаа энэ ариун сайн мэдээг тунхаглахад чиглэгдэх болсон юм. 2000 оноос эхлэн гадаадад нэгдсэн их цуглаануудыг зохион байгуулж, ялангуяа Угандад хийсэн Нэгдсэн их цуглаан нь дэлхийн мэдээний суваг болох CNN-р цацагдаж, цаашлаад Япон, Пакистан, Филиппин, Гондурас, Энэтхэг, Орос, Герман, Перу, Конго, Америк, Израйль, Эстон гэх газруудад нэгдсэн их цуглаануудыг хийсэн. Түүнчлэн манай Манмин Төв сүм нь итгэлийн хувьд маш хүнд дарамтанд байсан Пакистан улсад хүртэл, “шашны хувьд маш хатуу чанга дэглэмтэй” гэгдэх Энэтхэгт, мөн Иудей шашинтай Израйльд хүртэл сайн мэдээний үйлчлэлийг амжилттай хийж гүйцэтгэсэн бөгөөд Бурхан Аавын өгсөн алсын хараа бүх дэлхий даяар сайн мэдээ тараах үйлчлэлд бүх зүйлээ зориулан давшсаар ирсэн юм.

Үүний үр дүнд 2010 оноос хойш манай чуулганы хувьд 3 дахь чухал эрин үе буюу итгэгчдийн итгэлийн хэмжээ болон Тэнгэрийн орны хүсэл тэмүүлэл асар ихээр өсөх сүнслэг уур амьсгал дотор маш хурдацгайгаар өөрчлөгдөж байгаа бөгөөд Бурханы замчилж удирдсаны дагуу хүн төрөлхтөний эцсийн үе болох өнөө цагт дэлхийн 7.2 тэрбум хүмүүсийн авралын төлөө бүх зүрх сэтгэлээ зориулан шамдаж байна.

Ялангуяа Манмин төв сүм байгуулагдсаны 30 жилийн ойн баяраар “Бурханаас дэлхий рүү чиглэсэн дахин босгон байгуулалт буюу Шинэ эхлэл” хэмээн гэж айлдсанчлан шинэ зүрх сэтгэлээр дахин эхлэх хүсэл тэмүүлэлийг бүх л итгэгч нарт өгөгдөж ариун байдлыг өөрсөддөө бий болгохыг хичээн зүтгэж байна.

Эелдэг, ул суурьтай байх мэргэн ухаан

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж” (Иаков 3:17).



И Жей руг пастор

Хорон муу, атгаг санаа болоод гэм нүглээ хаясан хэн ч эв нэгдэл, амар тайван дотор сайхан сэтгэл, даруу зан, ухаалаг байдлын үр жимсийг ургуулна. Ямар ч нөхцөл байдалд шулуун шударгаар бусдын төлөө хандаж анхаарал халамж тавьдаг юм. Тэгвэл ул суурьтай болоод эелдэг байхын мэргэн ухаан гэдэг нь чухам юу вэ?

Эелдэг байдал гэдэг нь “сайн сайхан, үзэсгэлэнтэй зүрх сэтгэлийн анхилуун үнэр үг яриа ба үйл хөдлөлөөр илрэх байдал” гэсэн үг юм. Хэрэв бидний зүрх сэтгэл үнэнээр болоод сайнаар дүүрвэл бидний амнаас аяндаа сайн сайхан үг урсан гарч, үргэлж сайн зүйлийг л хийх болно. Гэвч сайн байна гэдэг нь цаг үргэлж л эелдэг, зөөлөн, найрсаг байхыг хэлдэггүй заримдаа эр зоригтой, хүчтэй, шийдэмгий байдалтай ч байдаг. Үнэний дотор магадгүй хоёр сонголт байж, мөн эдгээр нь хоёулаа зөв байлаа ч аль илүү Бурханы өмнө тааламжтай, Түүнд таалагдахыг нь Ариун Сүнсний хүчээр ялган таньж сонголттой хийх нь ухаалаг, ул суурьтай сонголт байх болно. Тэгвэл үүнийг гурав хувааж үзье.

1. Эелдэг зан чанар нь ямар ч нөхцөлд үнэнээр тухайн асуудлын голыг ялган таньж бусдад амар тайвныг бэлэглэж чаддаг

Сүнслэг сайны сэтгэл ба үнэнээр дүүрэн сэтгэлд харанхуйг зайлуулах сүнслэг эрх мэдэл гэж бий. Үүн шиг эелдэг хүн нь бусдад зөвлөгөө өгөхдөө тухайн асуудлын голыг олж, бусдын сэтгэлийг шинэчилж өөрчилж чаддаг. Амин хувиа хичээсэн хүн нь өөрийн эрх ашгийг харах юм уу сэтгэл хөдлөлдөө автаж, ялган таних чадваргүй байдаг бол харин хувиа хичээсэн зан байхгүй бол тухайн асуудлыг зөвөөр шийдвэрлэх арга замыг олдог. Амиа боддог хүн

өөртөө л үйлчилж, ‘миний юм’, ‘миний гэр бүл’, ‘миний нэр төр, эрх мэдэл’, ‘миний бахархал’, ‘миний тав тух’ гэх мэтийг л хайх болно.

Лук 12-р бүлэгт нэг хүн Есүс дээр ирээд гэр бүлийн өвийг тэнцүү хуваа гэж ахад минь хэлээд өгөөч гэхэд Есүс өв хуваах тухай юу ч айлдаагүй бөгөөд харин ч Лук 12:15т “Шуналын алив хэлбэрээс өөрсдийгөө хамгаал, болгоомжил. Учир нь элбэг хангалуун нэгний амь өөрийнх нь өмч хөрөнгөнөөс хамаардаггүй юм” гэж айлдсаны дагуу хамгийн чухал зүйл нь юу болохыг ойлгуулахыг хичээж байгаа талаар гардаг.

Энэ нь тэр хүний хувьд өөрийн шуналын сэтгэлийг хаяхгүй бол ах дүүтэйгээ үргэлж л зөрчилдөж тэмцэлдэж байх болно. Тиймээс Есүс түүнд энэ асуудлаас гарах хамгийн чухал суурийг нь зааж, ивээл ерөөл авах жинхэнэ зөв замыг заагаад зогсохгүй сүнслэг хариултыг өгдөг. Хэрэв эрхэм та өөрийнхөө зүрх сэтгэл рүү ухаалгаар харвал ямар ч асуудал байсан бодитоор хүлээн авч ойлгож чаддаг болно.

2. Эелдэг байх гэдэг нь ямар ч хэцүү нөхцөлд ч өөртөө сэтгэл хангалуун байж, Бурханы хүслийг ойлгож амар тайван байхыг хэлнэ

Бидэнд ухаалаг сэтгэл байвал хүнд нөхцөл байдалд орлоо ч айж түгших, сандрах, дургүйцэж, тавгүйтэх сэтгэл төрөхгүй (Филиппой 4:11-12). Урам хугарч, хэн нэгэнд гомдоллож “энэ ч хэцүү, тэр ч хэцүү байна” гэж хэлэхгүй. Хэдий хэцүү бэрхшээлтэй үед ч Бурханы ивээлээр дүүрэн байдаг учраас бүх зүйлд талархаж, баяр хөөртэй байж чаддаг юм.

Нөхцөл байдал өөрчлөгдөж, өөрсдийнх нь бодож, төлөвлөсөний дагуу явагдахгүй бол хүмүүс гомдоллож, дургүйцэж, уурлаж, хэн нэгнийг үзэн ядахад ч хүрдэг. Харин ухаалаг байдлын мэргэн ухааныг авсан хүн хэцүү байсан ч зүрх сэтгэлдээ амар тайван байж чаддаг. Тэд гайхаж, гутарч, сэтгэл гонсойх ч үгүй харин яагаад ийм явдал тохиолдсоныг Бурханы хүслийн дагуу танин мэдэж, ойлгодог байна. Яагаад гэвэл тэд Бурханы хайранд итгэдэг учраас амар тайван байдаг бөгөөд бүх нөхцөлд хамгийн зөв сонголтыг хийж чаддаг юм.

Бид өөртөө сэтгэл хангалуун байвал асуудлаа ухаалгаар зохицуулж, үргэлж сайныг дагаж, Ариун Сүнс биднийг үргэлж удирдан замчлах болно. Ингэж Бурханы хүсэлийн дагуу явж байна уу, эсвэл яг одоо зогсоод дараа

үргэлжлүүлэн хийх хэрэгтэй юу гэдгээ бид ялгаж чадна.

3. Эелдэг байх нь Зөвхөн Бурханы Үгэнд дуулгавартай байгаад зогсохгүй илүү ихийг хийхийг хэлдэг

Эцэг эх нь хүүдээ “Дүүгээ сайн хараад, гэрийн даалгавараа хийгээрэй!” гээд захиад явлаа. Гэрийн даалгавараа дөнгөж хийж дуусаад тэр хүү жаахан тоглож байтал ээж, аав нь ирээд гэрийн даалгавараа хийгээд дээрээс нь бас гэрээ цэмцийтэл нь цэвэрлэхчигсэн байжээ. Тэр хүү аав, ээжийнхээ сэтгэлийг ойлгохыг хичээж, хэлсэнээс нь илүү ихийг хийжээ. Аав ээж нь ийм хүүгээ хараад ямар их баярлаж, бас түүгээр бахархах бол?

Үүнтэй адил Бурханд хайртай хүн Түүний үгийг эелдэгхэн дагаж чадна. Цаашлаад Ариун Сүнсээр юу нь илүү сайн болохыг ч ялгаж чадна. Бурхан түүнд нэг зүйлийг хий гэж тушаавал Бурханы зүрх сэтгэлийг ойлгож хоёр эсвэл гурван, бүр түүнээс ч илүү ихийг хийх болно. Тэр үед Аав Бурхан маань ийм хүүхдүүдээ хараад маш их баярлаж “Миний жинхэнэ хүүхдүүд” гэж айлдах болно.

Итгэлийн амьдралд заримдаа хоёр зүйлийн нэгийг нь сонгох зайлшгүй шаардлагатай болдог. Нэг нь үнэн, нөгөөдүүл нь худал хуурмаг бол бид үнэн, зөвийг нь л сонгох нь мэдээж тэгвэл хэрэв тэр хоёр зүйл нь хоёулаа л зөв бол ихэнх хүмүүс өөрсдийн эрх ашгийг харан сонгохыг хүсдэг. Гэхдээ ухаалаг мэргэн ухаанд суралцсан хүн бол аль нь Бурханыг алдаршуулж, Түүнд таалагдахыг нь л сонгодог байна.

Ингэж, ухаалаг эелдэг байх мэргэн ухаан хүн нь зөвхөн Бурханы үг тушаалд дуулгавартай байгаад зогсохгүй мэдээж хийх ёстойгоос ч илүү ихийг хийж чадах болно.

4. Эелдэг байх мэргэн ухааныг авсан Элч Паул

Элч Паулын үйл хэрэг болоод үг яриа нь үзвэл тэрээр эелдэг, ухаалаг байдлын мэргэн ухааныг хэр зэрэг эзэмшсэнийг харж болно. Тэр Мосегийн хуулийг Эзэнийг хүлээн авахаасаа ч өмнө чандлан сахидаг байсан. Эзэнтэй уулзсанаасаа хойш бүхнийг зөвхөн сайн мэдээний төлөө зориулахаар шийдсэн. Тэр өөрт хэрэгтэй, өөрийн дуртай зүйлээ ч дагадаггүй байв.

Жишээ нь 1 Коринт 8:13т “Тиймээс хэрэв идэх юм миний ах дүүг бүдрүүлэх шалтаг болбол ах дүүгээ бүдрүүлэхгүйн тулд би хэзээ ч дахин мах идэхгүй” гэж хэлсэн байдаг. Үүгээрээ “Бид

хиймэл шүтээнд өргөсөн хоол хүнсийг идэж болох уу?” гэсэн асуултанд ч бас хариулт өгч байна. Мэдээж, та өөрөө хуурамч шүтээнд өргөсөн хоолыг мэдэж л байгаа бол идэхгүй байх нь илүү сайн хэрэг юм. Харин тухайн хоолны талаар бүгдийг нь мэдээгүй бөгөөд зайлшгүй идэх ёстой нөхцөл байдалд байвал идсэн ч буруутгагдах гэмд тооцогдохгүй юм (Ром 14). Энэ нь бол зүгээр л хоол идсэнээрээ хиймэл шүтээн шүтэхэд, оролцож байгаа хэрэг огтхон ч биш гэдгийг ойлгох хэрэгтэй.

Харин итгэл султай хүмүүст хиймэл шүтээнд өргөсөн хоол идэх гэх мэт зүйл нь эвгүй санагдаж байж болох юм. Мөн итгэлтэй хүмүүсийг хараад хиймэл шүтээн шүтэхэд оролцож байна гэж бодож ч болох юм. Эсвэл ийм мундаг итгэлтэй хүн идэж байгаа юм чинь би идэхэд зүгээр гэж бодоод идэж ч болох юм. Харин энэ бол зүгээр л хоол шүү дээ гэж бодоод идвэл энэ нь нэг их асуудал биш. Идэж байх үедээ хиймэл шүтээнд өргөсөн хоол гэдгийг мэдээд, янз бүрийн зүйл бодоод эргэлзэж идэх юм бол харин ч асуудал болж болзошгүй. Энэ мэтчилэн танд ямар нэг зүйлийг хийж болохгүй гэж санагдаж, мэдрэгдэж байсан ч та хийсээр л байвал сатанд өөрийнхөө эсрэг зарга хийж ял тулгах боломжийг олгоод байна гэсэн үг (Ром 14:23).

Паулын хувьд хиймэл шүтээнд өргөсөн хоолыг идэж болох ч хэн нэгэн түүнийг хараад бүдрүүлсэнээс тэрний оронд идээгүй байсан нь дээр юм гэж шийдсэн юм. Паулын ингэж бусдын төлөө гэсэн сэтгэлийг Бурхан хараад баярлаж бусад дагалдагчдаас илүү их хүчийг өгсөн. Бурхан мөн түүнд эр зориг, мэргэн ухааныг өгсөн учраас тэрээр итгэгчдийн хооронд байнгын тулгардаг асуудлууд болох гэрлэлт ба салалт, гэр бүл болон ажлын газарт гардаг хүнд хэцүү асуудал, Ариун Сүнсний бэлэг, Ариун зоогын ёслолын талаар асуусан бүх асуултанд хариулт өгч чадсан байна.

Энэ мэт ухаалаг байх мэргэн ухааныг авсанаар Бурханд таалагдах сонголтыг хийж, Түүний хүслийг зөв ялган таньж, сайхан үгс, сайн бүхнийг хүмүүсийн зүрх сэтгэлд суулгаж, үнэн дотор асуудлыг зөв шийдэж чадна.

Хайрт итгэлийн ахан дүүс нар минь, Зүрх сэтгэлдээ сайн болон хайраар дүүрч, ийм мэргэн ухааныг авсанаараа зөвхөн цэнгэг ус ундрах булаг мэт үзэсгэлэнт сайхан үг ба үйлсээрээ Бурханыг баярлуулахыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Монгол Манмин Сүм

Мэргэлийн цаг

Мэргөл	Цаг
Их мэргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мэргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мэргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мэргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мэргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мэргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.gcntv.org

Итгэлийн хадан суурийг өнгөрөөд сүнслэг итгэлд ойрхон байгаа ч яагаад сүнс рүү орж чадахгүй байгаа шалтгаан нь юу вэ?

Гурван үндсэн шалтгаан

Андуурах

◆ Итгэлийн хадан суурийг өнгөрөөд сүнслэг итгэлд ойрхон итгэлийн үе шат нь гаднаас харахад онцгойлон зэмлэх хорон муугийн шинж илрэн гардаггүй. Ямар нэгэн ч худал, хуурмаг, үйлс юм уу Бурханы үгэнд дуулгаваргүй хандах юм уу, хариуцсан үүрэг албаа алдагдуулалгүй сайн биелүүлдэг. Үргэлж залбирч, хэрэндээ хайрлаж, итгэдэг, сүнс рүү орохыг хүсэн тэмүүлдэг учраас өөрийгөө бүхнийг сайн хийж байна гэж бодож болох юм.

Харин Бурханы үүднээс харвал маш олон талаар төгс биш байдлууд их байдаг. Хэдийгээр өөрийгөө дуулгавартай дагадаг гэдэг ч Бурханыг харахад дуулгаваргүй байдал ч байдаг ба зөвхөн өөрийн үүднээс харахад сайн гэх зүйлүүд бий юм. Хааяа хааяа махан биеийн бодол санаанд автах үе байдаг ба өөрийнх нь бодлоор үнэхээр зөв мэт харагдах учир, чухам юу нь буруу болохыг ялгах чаддаггүй үе бас бий.

Махан биеийн дутмаг шинж чанарууд

◆ Махан биеийн дутмаг шинж чанар гэдэг нь хүн төрөхөөс аваад өсөж том болох явцдаа зайлшгүй үзэж, туулах, сурах ёстой, хийж чадах ёстой зүйлээ сураагүй, хийж чадахгүйн улмаас ийм байдал үүсдэг. Иймэрхүү шинж чанарууд хувь хүний хүмүүжил болон харилцаа, биеэ авч явах байдал зэрэг дээр илрэн гарч байвал сүнслэг итгэлтэй болж өсөхөд тэр хэмжээгээр том саад болдог.

Махан биеийн дутмаг шинжүүд удаан хугацааны турш зуршил болтлоо хөгжиж, байр сууриа олсон бол өөрийн байдлаа ухаарч чадахгүй төдийгүй олж мэдсэн ч түүнийгээ засахад бэрхшээл учирдаг. Жишээлбэл, хаалга хаахдаа хүчтэй савж хаадаг эсвэл хөлөөрөө түлхэж онгойлдог, эсвэл хоол идэхдээ их дуу чимээ гаргадаг, асгах гоожуулах, мөн хөлөө хүчтэй дэвсэлж, чимээтэй явдаг, эсвэл түүний амьдардаг гэрийг нь эсвэл өрөөг нь харвал маш замбараагүй, хайш яайш, бохир орчин, эсвэл ямар нэг багаж мэт зүйлсийг хэрэглэхээс буцааж байсан байранд нь тавилгүй замбараагүй тавьдаг

байж ч болох юм. Энэ мэт нэрлээд байвал олон махан биеийн дутмаг шинжүүд байж болох ч дээр дурьдсан шинжүүд маань үнэндээ зөв хүмүүжил авч чадаагүйн илрэл юм.

Махан биеийн дутагдлуудад илүү ноцтой зүйлүүд ч бас байдаг. Энэ нь бусдын үг ярианд анхаарал хандуулдаггүй ч юм уу, ярьж байхад яриан дундуур таслан орох, бусад хүмүүсийн үүднээс бодож чадахгүй, зэрэг зөвхөн “Өөрийнхөөрөө” амьдарч байхдаа өрөөл бусад анхаарал, халамж, тавих юмуу ойлгож өгөх чадвар дутмаг шинж чанарууд ч элбэг тохиолддог.

Иймэрхүү махан биеийн дутагдлууд нь хүний сэтгэл зүрх, үйл хөдлөл, бодол санаанд ч хүртэл нөлөөлөх болдог. Түүнчлэн ийм байдалтайгаар хувь хүмүүсийн харилцаанд болоод нийгмийн амьдрал, бүр цаашлаад итгэлийн амьдралд ч том асуудлуудыг үүсгэдэг. Мөн эргэн тойрондоо хүндрэл учруулж, бусдын, амгалан тайван байдлыг нь алдагдуулж тэр ч байтугай бусдыг бүдрүүлэх тохиолдол ч байдаг байна.

Бардам зан

◆ Бардамналыг хоёр хуваадаг: махан биеийн бардамнал, сүнслэг бардамнал. Магадгүй танд жаахан махан биеийн бардамнал байдаг ч илүү асуудал үүсгэж болзошгүй зүйл нь сүнслэг бардамнал ч байж болох юм. Учир нь ийм сүнслэг бардамналыг өөрөө олж мэдэж чадахгүй юм. “Энэ бардам зан байхнээ” гэх зүйлийг та ухаарч ойлговол хаях нь зайлшгүй ч асуудлын гол нь та өөрөө олж харж

чадахгүй, мэддэгүйд л байдаг юм. Өөрийн сурч мэдсэн сүнслэг мэдлэгийнхээ дагуу “Энэ нь зөв” гэж боддог зүйлс тань заримдаа сүнслэг бардамнал болж болох юм. Тиймээс зөв, буруу хоёрыг жинхэнэ үнэн дээр суурилан ялгаж таних чадвартай байхаас гадна магадгүй өөрийгөө магтах, дөвийлгөх бодол байна уу гэж үргэлж өөрийгөө нарийн хянаж байх хэрэгтэй.

Бодит жишээнүүд

1

Сүнслэг хайр дутагдах тохиолдол

Сүнслэг хайр дутагдана гэдэг нь ерөнхийдөө ‘Би’ гэсэн мэдрэмж маш өндөр байдаг хэлбэр юм. Ийм мэдрэмж байх тусам өөрийгөө даруу болгож, бусдыг хайрлах, үйлчлэх сүнслэг хайр тэр хэмжээгээр дутуу гэсэн үг юм. Та одоо болтол өөрөөрөө бахархах, магтуулах, хүсэлтэй мөн хувийн хүсэл сонирхолтой байж болох юм.

Өөрийгөө олж мэдээд өөрчлөхийн тулд бодит байдлаасаа өөрлүүгээ харах хэрэгтэй. Гэхдээ ‘Би’ гэсэн мэдрэмж хүчтэй байх үед энэ нь сайн болдоггүй. Таны зүрх сэтгэлд сүнслэг хайр хэр хэмжээгээр бий болсон байна тэр хэмжээгээр өөрийн дотор байгаа ‘Би’-гээ хаяж чадна.

болох нь маш чухал юм. Хайрыг авах ёстой үедээ сайн авалгүй өөрийгөө гол төв болгон чухалчилсан амьдралаар амьдарч байгаад Есүс Христийг хүлээн авсан ч урьдын адил ‘Би’ гэсэн мэдрэмж хүчтэй байх тул бусдаас ч хайр авч чадахгүй байдаг. Иймд үүнийг өөрчлөхийн тулд удаан хугацаанд өөрийгөө бий болгож байснаасаа эсрэгээр нь хөгжүүлэх хэрэгтэй.

Хичээнгүйлэн өөрийгөө даруу болгож, үйлчлэлээр Эзэний хайр, Бурханы хайрыг зүрх сэтгэлээрээ мэдэрч, өөрийгөө тэр хайраар өөрийгөө дүүргэнэ гэсэн үг. Тэгж байж л та бусдад сүнслэг хайрыг өгч, бусдыг ойлгож, сэтгэлдээ багтаан өвөрлөж чадна.

таардаггүй хүнийг хараад тавгүйтэх мэдрэмж төрдөг бол таны дотор атаархах, атгаг сэтгэл байна гэсэн үг. Бүр түүгээр ч зогсохгүй таны иймэрхүү таагүй мэдрэмж нүүрний хувирлаар ч илэрдэг байж болох юм.

Энэ мэт хүний уг сэтгэлийн гүнд нуугдсан атаархах, атгаг сэтгэлийг олж мэдэн үндсээр нь хаясанаар л та сүнс рүү орох боломжтой. Мөн бусдын эрх ашгийг хайж, чин сэтгэлээсээ үнэнтэй цуг баярлаж, өрөөл бусад танаас сайн, илүү байвал чин сэтгэлээсээ талархах гэх мэт ийм сэтгэлийг бий болгосоноор Бурханд сайхан сэтгэлийн анхилам үнэрийг өргөж чаддаг байх хэрэгтэй юм.

2

Өөрийгөө өргөмжилөх мэдрэмж хүчтэй байвал

Үргэлж өөрөөрөө амьдарч ирсэн хүн нь өөрийн мэдлэг, туршлага зэрэг өөрт байгаа бүхнээ зөв гэж үздэг учраас бусдын төлөө бодож, нулимс урсган хайрлах хайр дутмаг байдаг.

Энэ мэтчилэн одоогийн зүрх сэтгэлийн байдал ба өсөж бойжихдоо өөрийгөө хэрхэн бүрдүүлсэн

3

Атаархах сэтгэлээс үүдэн гарах тохиолдол

Атаархал гэдэг заавал хэн нэгнийг үзэн ядах биш өрөөл бусадтай өөрийгөө харьцуулахад сэтгэл тань тавгүйтэж гуниглах, санаагаар унах байдлаар ч илрэн гардаг. Хэрэв та бусдад хүлээн зөвшөөрөгдөхөөс илүү өөрийн сайн тал, гавьяа шагналаа илчлэхийг хүсдэг, эсвэл тантай

4

Шунал, махан биеийн хүслийн улмаас

Галат 5:24д “Христ Есүст хамаатай хүмүүс өөрсдийн махан биеэ бузар хүсэл, тачаалынх нь хамт загалмайд цовдолсон ажээ” гэсэн байдаг. Махан биеийн дур хүслийг хаяж байж л сүнслэг итгэлтэй болдог. Зөвхөн сүнслэг хайраар л дамжуулан жинхэнэ аз жаргал баяр баясгаланг мэдэрч чадна.

“Энэ удаад Солонгост очсон нь манай гэрийнхэнд хариулт ба ерөөл авах сайхан боломж байлаа”

Августин Вово итгэгч (60 нас; Парис, Франц)



Э мил Вово, Августин Вово болон тэдний хүү 15 жил арьсны өвчнөөр шаналж байгаад эдгэрсэн Фил (дунд)

Би Католик шашинтай гэр бүлд төрж, өссөн учир Бурханыг илүү сайн мэдэхийг хүсч, Библи унших явцад ч үл ойлгогдох маш их байдаг байлаа. Мөн жинхэнэ итгэлийг олохын төлөө залбирдаг ч миний сүнс маань сэтгэл хангалуун байдлыг бус харин ч бүр цангадаг байлаа. Эцэст нь би католик сүмээс гарч Христийн цуглаанд явахаар болж 2012 онд би анх И Жей руг пастор, болон Солонгост байдаг Манмин төв сүмийн тухай хамт ажилладаг Жанет Д у в р е г э э с сонссон.

Одоогоос 4 жилийн өмнө нөхөр Пак Чол хүн сүмд үйлчлэгчийн тусламжтайгаар сүмд ирээд 2010 онд Манмин төв сүмд бүртгэгдсэн билээ.

Тухайн үед би гурван ээлжээр ажилладаг байсан болохоор Эзэний Өдрийг бүтэн сахиж чаддаггүй байлаа. Тэгэхэд манай бүлгийг хариуцсан ахлагч Ким Сү жон пастор манайд айл эргэлтээр ирээд Эзэний өдрийг бүтэн сахидаг болохын төлөө залбирах хэрэгтэй гэж зөвлөсөн бөгөөд бид ч үүний төлөө залбирч эхэлсэн юм. Мөн И Сү жин пастортой уулзаад хариултаа авахын тулд хэрхэн залбирах талаар мэдэж авсан юм.

Үүний дараа би ажлын өдрүүдэд ажилладаг өөр нэг хэсэгт шилжсэн бөгөөд залбирлынхаа хариуг Бурханаас авч, залбирах хүсэл улам ихээр төрж, оройн Даниел залбиралд оролцдог болж мөн Бурханы хайрыг мэдэрч эхэлсэн юм.

“Бурханы хайрыг хүрч, мэдрэх итгэлийн амьдрал үнэхээр аз жаргалтай байна”

И Жэ ёон сүмд үйлчлэгч 31 настай, 3-р тойрог 23 бүлэг, Өмнөд Солонгос



Тэр өдөр бид бас л кино үзсэн бөгөөд энэ бол зүгээр нэг кино шүү дээ л гэж бодож байлаа. Гэвч бид хоёр энэ машины ослоор дамжуулан кинонд хэт их шунаж, Бурханыг хайрлаж, тэнгэрийн орны хүсэл тэмүүлэлээ бүү алдаасай үргэлж Бурханы хамгаалалтанд дотор амьдрахыг хүсэж буй Түүний агуу хайрыг мэдэрсэн юм.

6 сарын 13нд И Жей руг пастораас ерөөлийн залбирал авч байгуулагынхаа хэмжээнд ажлын үр дүнгээрээ ганцаараа шалгарч баярын бичиг болон шагнал авсан. 2014 оны хагас жилээр хувийн үнэлгээгээр хамгийн их өндөр орлоготой байсан. Бүх алдар, магтаал, талархал, хүндэтгэлийг үргэлж сайн зүйлийг надад өгдөг Бурхандаа өргөж байна. Халлелүяа!

Нөхөр бид хоёр кино үзэх маш дуртай бөгөөд ажилладаг компанийхаа кино клубын гишүүн, бүр байнгын үйлчлүүлэгч болох хэмжээний киноны хорхойтон байлаа. 2014 оны 1 сарын 9нд клубынхээ гишүүдтэй хамт үзсэн кино маань үнэнээс маш хол, үнэний эсрэг байхыг мэдээд сэтгэл маань шаналж, гэмших мэдрэмж төрж байсан. Сургаалиар дамжуулан худал хуурмаг зүйлсийг хаях хэрэгтэй, дэлхийн зүйлээс өөрийгөө татаж, таслан зогсоох хэрэгтэй гэдэг талаар сонсож байсан учраас тэр юм.

Маргааш нь гэрлэн дохион дээр ногоон гэрэл асахыг хүлээгээд зогсож байтал араас өөр нэг суудлын машин ирээд манай машиныг мөргөсөн үйл явдал болсон юм. Тэр үед бодохдоо бид жирийн биш кино үзсэн болохоор л Бурхан хамгаалж өгсөнгүй дээ гэж бодсон. Мөн цагаан сарын үеэр зогсоолд тавьсан машиныг маань мөн л шүргэж гэмтээсэн байлаа.

Түүнээс хойш И Жей руг пасторын *Загалмайн Утга Учир, Тэнгэрийн Орон I болон II, Там* гэсэн номнуудыг уншиж байхдаа жинхэнэ итгэлийн амьдралын амтыг мэдэрч эхлэсэн юм. Тэгээд долоо хоног бүр бүтэн сайн өдрийн цуглаанд интернетээр оролцдог болсон. Энэ мөргөлд оролцохын тулд шөнийн гурван цагаас өмнө босох шаардлагатай байсан ч надад ердөө ч хэцүү байгаагүй. Дараа нь би 5дахь өдрийн шөнийн мөргөлд бас оролцдог болсон. И Жей руг пасторын сургаалууд бүгд Библи дээр суурилагдаж байгаа нь надад маш их гүн сэтгэл төрүүлсэн. Гадаадад байдаг нөхөр, хүүхдүүд маань хүртэл мөргөлд оролцдог болсон.

2014 оны 2 сард интернетээр Би Манмин Сүмд бүртгэгдсэн юм. Тэгж байтал Белгийн Ейно Манмин цуглаан (хариуцагч Ну хёон суг СМТ)-д цуглаан болно гэсэн сураг дуулдаж, маш их хүсэн тэмүүлж байсан Манмин төв сүмээс номлогч ирж эдгэрэл ивээлийн цуглааныг удирдана гэсэн билээ. 5 сарын 24 нд гэр бүлийнхэнтэйгээ хамт хүүгийнхээ өвчний төлөө залбирч байсан залбирлынхаа хариуг авахаар тэр сүм рүү явсан.

Миний хүү Фил Вово 8 настай байхаасаа эхлээд 15 жилийн турш атопик өвчнөөр шаналж байлаа. Эхлээд жаахан толбонууд биеэр нь гардаг байснаа сүүлдээ бүр даамжирч бүх биеэр нь гардаг болсон. Үүнээсээ болж тэр идэж, ууж, явж, унтаж, сургуульдаа ч явж чадахгүй болсон юм.

Эмч нар нэг төрлийн алерги маш хүндэрсэн тул одоо эмчлэх тусгай эмчилгээ байхгүй. Өвчнийг нь намдаагаад, яр шархыг нь багасгах л арга хэмжээ авна гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Хүүгийн маань арьс нь муудаж, ясанд нь тулсан ч ямар ч сонголт байхгүй л байлаа.

Цуглааныг И Хи сон пастор (Манмины бүх салбар чуулганы ерөнхий удирдагч) “Итгэл” гэсэн сэдэвтэй сургаалыг айлдаж, сургааль сонсоод ивээл авсан хүүд маань итгэлээрээ эдгэрэх боломжтой юм байна гэсэн найдвар төрж, сэтгэлдээ шийдсэн юм. Сургаалын дараа И Хи сон пастор гар алчуурын залбирал (Үйлс 19:11-12)-г хүү маань авч тэр даруй ууж байсан эмнүүдээ бүгдийг нь тэр дор нь зогсоосон. Тэр орой нь түүний бие яг л шагаж байгаа мэт халуун оргиж, бүх бие нь, нүүр нь хүртэл тэсэхийн аргагүй аймшигтай өвдөж, маш их шаналж байлаа.

Тэгсэн ч хүү маань И Хи сон пасторын номлосон Даниел ба түүний найз нар галд хаягдсан тухай санаж маш их тэвчиж байсан. Нэг долоо хоногын дараа Бурханы хүч нөлөө мэдрэгдэж эхлэсэн юм. 15 жилийн турш зузаарч хатсан шархны тавнууд нь өөрөө аяндаа л ховхорч унаж арьс цоо шинээр дахин төлжиж маш цэвэрхэн болсон юм. Халлелүяа!

Ингэж эдгэрлийн ивээл ерөөл авсаныхаа дараа манай гэр бүлийнхэн 2014 оны 6 сард Сөүлын Манмин сүмд очсон билээ.

Бид И Жей руг пастортой баяртайгаар уулзаж, залбирал аваад

Муан Амтат усны газар очиж амтат усан дотор долоо удаа шумбасан. Гайхамшиг дахиад л болсон. Бидний арьс бүгд маш цэвэрхэн бүр гөлгөр болсон. Бид усанд орсоньхоо дараа ямар ч тос хэрэглэх шаардлагагүй болсон бөгөөд хүүгийн маань биеийн байдал бүр сайжирсан. Надад яг л зүүд юм шиг санагдаж байлаа. Хүгийн маань өвчин бид бүхнийг бүгдийг нь зовоож байсан ч биднийг агуу хайрын Бурхантай минь уулзуулж өгсөн юм даа.

Бүхий л алдар, магтаал, талархалыг Бурхандаа өргөж байна.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойши мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@manmin.org
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин